



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/180

Хэрлэн сум

Мал амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3, 21.3.1, 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт байгаа төлөвлөгөөт мал, амьтныг угаалга, туулгалт, боловсруулалтад хамруулах арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2.Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн графикт хугацаанд нь сум орон нутагтаа чанартай зохион байгуулж, багийн Засаг дарга нарыг хуульд заасны дагуу үүрэгжүүлэн, малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, уг арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийж заавар журмыг баримтлаагүй малчин, мал бүхий иргэд, холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Баярхүү)-т, гүйцэтгэлийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний дотор танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



